8. Зуухыг засварт оруулахын өмнө захиалагч бүрэн цэвэрлэж, гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх бөгөөд их засварын үед гүйцэтгэгч станцын дүрэм, журам шаардлагын дагуу ажлын байрыг цэвэрлэж ажиллах, шаардлага хангахгүй тохиолдолд, тухайн үеийн хяналт шалгалтын протоколоор нарядыг хурааж ажил гүйцэтгээгүйд тооцож, станцын дотоод журмын дагуу ажлын байрны цэвэрлэгээнд ноогдох хариуцлагыг хүлээлгэнэ.
9. Металл шинжилгээ хийх шугам хоолойн өнгөлөгөөг зүлгүүр, зүлгүүрийн машин, хий, элсэн буу зэргээр хийнэ. (Металл хорогдолгүй арга хэрэглэх)
10. Төрөл бүрийн багаж, хэмжих хэрэгслэл, тоног төхөөрөмж, засварын үед хэрэглэх багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх шаардлагатай.
11. Засварын өмнөх туршилтын үнэлгээг гэрээний хавсралт болгон тухайн үед нь оруулна.
12. Техникийн бүх бичиг баримт, формуляруудыг компьютерт хийж хөтлөнө. Компьютерээр хийгээгүй тохиолдолд хүлээж авахгүй .
13. Тендерийн бичиг баримтуудыг бүрдүүлэхдээ тендерт оролцогч байгууллага нь Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/259 дугаар тушаалын хавсралтаар өөрчлөлт орсон АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТЕНДЕРИЙН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ-ийн дагуу тендерийн бичиг баримт маягтуудыг боловсруулж ирүүлнэ. Үүнээс өөр байдлаар хийж бэлтгэсэн тендерийн бичиг баримтыг хүчингүйд тооцохыг анхааруулж байна.
14. Гүйцэтгэгч компани хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн байцаагч инженер томилон ажиллуулна. Засварын ажлын явцад ХАБЭА-н зөрчил доголдолгүй ажиллуулах ажил зохион байгуулах үүргийг гүйцэтгэгч байгууллагын удирдлага, ажлын нарыдаар үүрэг хүлээгчид шууд хариуцна.
15. Гүйцэтгэгч байгууллага уур, усны коллекторууд, тэдгээрийн хийцийн шугам хоолойг угсрах ажил гүйцэтгэхдээ дараах техникийн шаардлагуудыг заавал биелүүлэх ёстой.
16. Гүйцэтгэгч тал шугам хоолойн угсралтын үеийн гагнуурын оёдлыг гагнахдаа захиалагчаас гаргаж өгсөн технологи зааврыг дагаж мөрдөнө.
17. Гүйцэтгэгч нийлүүлэхээр тендерт тусгагдсан нэр бүхий сэлбэг, материалыг өөрсдөө бүрэн хангаж нийлүүлэх бөгөөд шаардлагатай сертификат, туршилт шалгалтын протоколуудын хамт нийлүүлнэ.
18. Гүйцэтгэгч компани хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн байцаагч инженер томилон ажиллуулна. Засварын ажлын явцад ХАБЭА-н зөрчил доголдолгүй ажиллуулах ажил зохион байгуулах үүргийг гүйцэтгэгч байгууллагын удирдлага, ажлын нарыдаар үүрэг хүлээгчид шууд хариуцна.
19. Гүйцэтгэгч тал халах гадаргуу, экран хоолой, агаар халаагч, таазны уур халаагчийн бүх гагнуурын оёдолыг зөвхөн аргон гагнуурын аргаар гагнах бөгөөд 1.1, 1.2 категоритой, эрх бүхий 4-оос доошгүй аргон гагнуурчинтай байх шаардлагатай.

Зуухны хийцийн маталттай хэсгийн хувьд дараах шаардлагыг хангах ёстой.

1. Хийцийн маталттай булангийн сунасан хэсгийн ханын зузааны хамгийн бага хэмжээ нь 3.8мм түүнээс дээш байх ёстой. Бусад хурц уур, тэжээлийн усны булан хоолойн хувьд тендерийн материалд заагдсан хэмжээний ханын зузааны доод хязгаараас бага байх ёсгүй.
2. Хийцийн маталттай хэсгийн зууванжилт нь 8%-иас хэтрэх ёсгүй.
3. Хийцийн маталттай хэсэг болох булангуудын хоолойн гадаад, дотоод гадаргууд цууралт ан цав, урагдалт, язралт, хэрчлээс, атираа нугалаа үүссэн байх ёсгүй.

Гагнуурын электрод, гагнуурын утасны хувьд:

Хийцийн болон угсралтын гагнуурын оёдлыг аргон болон цахилгаан гагнуураар гүйцэтгэнэ.

Хийцийн болон угсралтын гагнуурын оёдлыг аргон болон цахилгаан гагнуураар гүйцэтгэнэ. Гагнуурын электродын техникийн доорхи үзүүлэлт болох гангийн химийн найрлагын нарийвчилсан шинжилгээ, механик туршилт бат бөхийн шалгалтуудыг Монгол улсын эрх бүхий байгууллагаар хийлгэж баталгаажуулж акт протоколыг, электродны үйлдвэрийн

сертификатын /эх хувь/ хамт захиалагчид өгч зөвшөөрөл авсаны дараа гагнуурын ажлыг эхлүүлнэ.

Гагнуурын электрод нь гагнуур хийх жигд тасралтгүй гагнагдаж байх ёстой /электрод нь далий хазгай асалтгүй байх ёстой/ бөгөөд явцад элдэв нүх, сүв, металл биш хольц зэрэг согогууд үүсэх ёсгүй.

Гагнуурын электродны бүрхүүлний зузаан жигд, өнгө нь жигд хуурай, гэмтэлгүй байх ёстой.

Гагнуурчин болон гагнуурын оёдлын чанарын шаардлагын хувьд:

1. Халах гадаргуун гагнуурын ажлыг 1.2-оос дээш категори бүхий 6-р зэрэгтэй гагнуурчин гүйцэтгэх бөгөөд мэргэжлийн категори зэргийн эрх бүхий хүчинтэй үнэмлэхтэй байна. Гагнуурчны үнэмлэхний баталгаажуулалт, сунгалтанд зөвхөн Эрчим хүчний яамны харъяа байгууллагын эрх бүхий лабораториуд болон Монголын материал судлал гагнуурын нийгэмлэгийн баталгаажуулалт сунгалтыг тооцно. /Эрх бүхий бус, мэргэжлийн бус аль нэг компаний үнэмлэхийг тооцохгүй/. Гагнуурчин нь тухайн компанийн үндсэн ажилтан байх бөгөөд сүүлийн 1 жилээс доошгүй хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг компани төлсөн байх ёстой.
2. Тендерт нэр ирүүлсэн эрх бүхий гагнуурчдаас захиалагч тал гагнуурын онолын болон дадлагын шалгалтыг авч зэрэг категориыг баталгаажуулна. Хэрэв тухайн шалгалт өгсөн гагнуурчин нь тендерт ирүүлсэн категори зэргийн шаардлагыг хангахгүй бол тухайн компанийн тендерийн материал нь шаардлагад нийцэхгүй болох үндэслэл болно.
3. Гүйцэтгэгч нь хийцийн болон угсралтын үед хяналт шалгалт хийх гагнуурын инженертэй байх
4. Хийцийн болон угсралтын үеийн бүх гагнуурын оёдлыг зохих технологи дүрэм стандартын дагуу ирмэгийн боловсруулалт хийж, зай зазорыг тааруулсан байх ёстой.
5. Гүйцэтгэгч нь гагнуурын оёдлын технологи мөрдөлт болон гагнасан гагнуурын оёдолд 100% гадаад үзлэг, хэмжилт хийж акт протоколоор баталгаажуулж, холбогдох гагнуурын формуляр, гагнуурчны үнэмлэхний хүчинтэй хуулбарыг хавсаргасан байх ёстой.

ЗАСВАР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА

1. Засварт оролцох гүйцэтгэгч байгууллагын (туслан гүйцэтгэгч мөн хамаарна) ажиллагсад нь Эрчим хүчний үйлдвэрт мөрдөгдөж байгаа ТАД, ААД, ГАУСД, ХАБЭА хуулийн зохих мэдлэгтэй ээлжит шалгалт өгсөн мэргэжлийн үнэмлэхтэй байна.
2. Тухайн ажлын байранд ажиллах хүмүүс шаардлагатай хамгаалах хэрэгсэл, ХАБЭА-н хувцасаар бүрэн хангагдсан, эрүүл мэндийн үзлэгт орсон, энэ ажилд эрүүл мэндээр тэнцэх хүмүүс байна.
3. Ажлын байрыг байнга эмх цэгцтэй, хог хаягдлыг тухай бүр нь зайлуулж, шат тавцангууд болон эд ангиудыг шуурхай ажиллагаанд /ашиглалтын ажилд/ саад болохооргүй чөлөөтэй байлгах үүрэг хүлээнэ. Гарсан дулаалгын хогийг зөвшөөрөгдсөн зориулалтын хогийн цэгт зөөж хаях үүргийг гүйцэтгэгч бүрэн хариуцна.
4. Тухайн ажлын байранд байгаа хийц, шугам хоолой, хаалт арматур, гэрэлтүүлэг, болон бусад эд ангиудыг дур мэдэн өөрчлөх , авахыг хориглоно.
5. Засварт оролцох гадны байгууллагын ажиллагсад нь “ДЦС-3” ТӨХК-ийн дотоод дүрэм журам, ХАБЭА-н талаар мөрдөгдөж байгаа дүрэм, “Цахилгаан ба дулааны тоног төхөөрөмжинд цоож, пайз тавих, авах журам” мөрдөх ба эдгээрийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, торгууль, шийтгэлийг мөн адил мөрдөж ажиллах үүрэгтэй.
6. Ажлын онцлогоос хамааруулж зарим нэг тоноглол, үзельд засвар хийхдээ тусгай шат тавцан барих, аюулгүйн зон татах, анхааруулах тэмдэг плакат өлгөх, шаарлагатай гэж үзвэл доош юм унахаас сэргийлсэн тор татах хүртэл ажил зохион байгуулахыг гүйцэтгэгч байгууллагын удирдлага, ажил удирдагч, ажил гүйцэтгэгч нар шууд хариуцна.

7. Ажлын байранд галын хэсгийн зөвшөөрөлгүй, галын нарядгүйгээр гагнуурын болон галын аюултай ажил гүйцэтгэх, ил гал түлэх, зөвшөөрсөн зориулалтын цэгээс бусад газар тамхи татахыг хориглоно.
8. Гүйцэтгэгч компани хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн байцаагч инженер томилон ажиллуулна. Засварын ажлын явцад ХАБЭА-н зөрчил доголдолгүй ажиллуулах ажил зохион байгуулах үүргийг гүйцэтгэгч байгууллагын удирдлага, ажлын нарыдаар үүрэг хүлээгчид шууд хариуцна.
9. Засварын үед оосорлогч дохиочноор ажиллах хүмүүс мэргэжлийн үнэмлэхтэй байх ёстой.

ЗУУХ№10-Н ГРАФИКТ ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ТЕНДЕРИЙН ЗААВАЛ БИЕЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ

ДЦС-3 ТӨХК-ны ӨДС-ын БКЗ-220-100/4С маркийн Зуух№10-н 2024 оны графикт их засварын ажил гүйцэтгэхдээ хугацаанд нь багтааж чанартай гүйцэтгэх, ашиглалтын явцад хүндрэлтэй байдаг зүйлүүдийг оновчтой шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэв. Иймд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Засварын ажлын зохион байгуулалтын талаар
 - 1.1. Гүйцэтгэгч байгууллага засварын ажлын явцад мэргэжлийн удирдлагаар тасралтгүй хангаж долоо хоног бүр ажлын явц, тайланг бичгээр өгч байх.
 - 1.2. Засварын ажлыг графикт хугацаанд нь чанартай гүйцэтгэж дуусгах бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
2. Зуухны найдвартай ажиллагааг хангах зорилгоор
 - 2.1. Зуухны тэжээлийн усны автомат регуляторын засвар, угсралтыг чанартай гүйцэтгэх, ашиглалтад зүгшрүүлэх.
 - 2.2. Зуухны өрлөг дулаалгыг технологийн дагуу стандарт хэмжээнд гүйцэтгэх
 - 2.3. Усан сорилт магадлал хийж, УМХГ-ын байцаагчийн зөвшөөрөл авч, ажиллуулах эрх авах
 - 2.4. Зуухны АҮК нэмэгдүүлэх.
 - 2.5. Зуухны төрөл бүрийн хийцүүдийг өөрийн механик цехэд суурилагдсан тоног төхөөрөмжөөр зургийн дагуу /зургийн хэмжээ, заагдсан материалыг дур мэдэн өөрчлөхгүйгээр/, чанарын өндөр түвшинд гүйцэтгэх.
 - 2.6. Зуухны эргэх механизмийн угсралтыг чанартай гүйцэтгэх, ашиглалтанд зүгшрүүлэх.
 - 2.7. Эргэх механизмийн халалт, доргио хэвийн хэмжээнд байх.
 - 2.8. Тоосон системийн илүүдэл агаар соролт норм хэмжээнд байх.
 - 2.9. Төрөл бүрийн хийцүүдийг өөрийн механик цехэд суурилагдсан тоног төхөөрөмжөөр зургийн дагуу /зургийн хэмжээ, заагдсан материалыг дур мэдэн өөрчлөхгүйгээр/, чанарын өндөр түвшинд гүйцэтгэх.

ЗУУХ №10-Н ИХ ЗАСВАРЫН ДАРАА ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГУУД

- Зуухны бүхий л горим үзүүлэлтүүд нормт хэмжээнд байх
- Эргэх механизмууд доргио, халалтгүй хэвийн тогтвортой ажиллагаатай байх
- Зуухны их засвар хийсэн бүхий л хэсэгт өнгө үзэмж сайтай байх
- Дүүжин татлага, хөдөлгөөнтэй болон хөдөлгөөнгүй тулгууруудын ажиллагааны тооцоог гаргаж, халуун хүйтэн тохиргоо туршилтыг хийж, акт протоколыг гаргаж өгөх
- Шугам хоолойн системийн өөрөө компенсацлах чадвар, шугам хоолойн уклон, налууугийн тооцоог гаргаж, түүний дагуу угсарч акт протоколыг гаргаж өгөх
- Шугам хоолойн дулаалгыг стандартын дагуу чанартай хийсэн байх

ЗУУХНЫ ИХ ЗАСВАРЫН ҮЕД БҮРДҮҮЛЭХ ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

А. ГҮЙЦЭТГЭГЧИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ.

- Эрчим хүчний яамны тусгай зөвшөөрөл
- Засвар хийх хүмүүсийн нэрс , мэргэжлийн зэрэг
- ААД, ТАД, шалгалт өгсөн байдал
- Засварт хэрэглэх багаж, тоног төхөөрөмжийн жагсаалт
- Засварын ажилд мөрдөх технологи, зураг , схем
- Хийгдсэн ажлын товчоо, жагсаалт
- Гэрээгээр ажил гүйцэтгэгчдийн нэрсийг / Ажил гүйцэтгэгч, хариуцлагатай удирдагч, оосорлогч, дохиочин / гэх мэт хавсаргах
- Гэрээ дүгнэсэн протокол.....3%
- Гэрээ..... 3%
- Үе шатны ажлын хуваарь.....3%
- Ажлын гүйцэтгэл.....3%
- Материалын тайлан.....3%
- Хуучин сэлбэг материал тушаасан баримт2%
- Техникийн акт формуляр3% Хэрэв өөрчлөлт хийгдсэн бол батлагдсан зураг схем, техникийн шийдвэр, Хийгдсэн ажлыг тодорхой бичих.
- Ашиглалтанд хүлээлгэн өгсөн акт.....3%
- Цахилгаан хөдөлгүүрт туршилт хийсэн акт.....3%
- Хэрэглэсэн материалын сертификатыг
- Хэрэглэсэн электродны сертификатыг
- Доргионы хэмжилт, үнэлгээ өгсөн хүний гарын үсэг
- Эргэх механизмын голны цохио үзэж шалгасан тухай зураг, хэмжилтийн дүн шинжилгээг тусгасан байх. Формулярууд.Актанд холхивчны дугаар, хэмжилт хийсэн баримтыг нэг бүрчлэн бичих.
- МСГЛ-н үзэж шалгасан тухай протокол, акт
- Узель зангилгаа тус бүрээр солигдсон, засварласан эд ангийн судалгаа гаргах

Б. ЗАХИАЛАГЧИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ.

- Их засварт хүлээлгэн өгсөн акт.....3%
- Их засварын өмнөх ба дараах горимын туршилт...1%
- Их засварын өмнөх доргионы хэмжилт ..1%
- Их засварын ажлын эзэлхүүн 1 %
- Их засварт хэрэглэгдэх материалын жагсаалт 1%
- Металлын шинжилгээний ажлын эзэлхүүн 1%
- Их засварын дараа тоноглолд тавигдах техникийн нөхцөлүүд



ДУЛААНЫ III ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Төсөв зохиох тарифт цалинг
батлах тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 20.1.10, Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамт (тариф)-ын хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалт, Эрчим хүчний яамны 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн в/569 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Компанийн үндсэн болон туслах тоноглолын их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, сантехникийн ажлын төсөв зохиох тарифт цалинг хавсралтаар баталж, 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

2.Батлагдсан тарифт цалингаар төсөв зохиохыг Төсвийн инженер (Н.Нямгэрэл), Нормчлолын инженер (Ж.Гочоо) нарт үүрэг болгосугай.

3.Төсөв зохиох тарифт цалин шинэчлэн баталсантай холбогдуулан хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт эдийн засгийн хэлтсийн дарга (Л.Оюун-Эрдэнэ)-д даалгасугай.

4.Төсөв зохиох тарифт цалин шинэчлэн баталсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2022 оны А/27 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Л.ЭРХБААТАР

xx-3.2.d:/УУАЧГЗББ20221004

1701013103

УЛААНБААТАР ХОТ
“Дулааны 3-р цахилгаан станц” ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2022 оны 10 дугаар
сарын 04 ны өдрийн А/175 дугаар
тушаалын хавсралт
УЖМ0063 2546101
1116224004

Төсвийн тарифт цалин түүний итгэлцүүр

№	Үзүүлэлтүүд	Мэргэжлийн зэрэг					
		I	II	III	IV	V	VI
1	Итгэлцүүр	1.0	1.11	1.25	1.44	1.66	1.92
2	Тарифт цалин	4,190.48	4,651.43	5,238.10	6,034.29	6,956.20	8,045.72

-*-

**ЗУУХН№10-Н 2024 ОНД ХИЙГДЭХ ҮНДСЭН ХЭСГИЙН ИХ ЗАСВАРЫН
АЖЛЫН ЭЗЭЛХҮҮН**

Д/д	Ажлын эзлэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1. Барабан				
1	Хоёр талын үзлэг хийх люкны М41-н болтыг бүрэн тайлж авах. Люкийг бүрэн онгойлгож дотоод үзлэг хийх.48ш циклон тус бүрийг нэг бүрчлэн гадагш гаргах.	Ком	1	
2	Дээд малгайн хэсэг салгах. Циклон тус бүрийн доторх, гаднах хаг хусамыг бүрэн цэвэрлэх, засварлах угсрах. Таваг болон сеткануудыг засварлах. Тогтсон хаг хусмыг цэвэрлэх. Унасан, салсан эд ангиудыг сэргээн засварлах. Дутуу эд ангийг гүйцээх. Гагнах. бэхлэх. Хуучин жийрэгнүүдийг хусаж цэвэрлэх, шинээр жийрэг бэлдэж тааруулах, болтнуудын резьбануудыг сэргээж 2 люкийг бүрэн нягтруулж хаах.	Ком	1	
3	Металлын гадаргуу дээр өнгөлгөөнүүдийг хийж шалгуулах. Илэрсэн гэмтлийг засварлах.	м ²	2,2	
2. Потолокны тавцан				
1	Өрлөг, дулаалга задлах, гарсан дулаалгын хог ачиж зөвшөөрөгдсөн зориулалтын газарт хаях.	м ³	22,5	
2	Өрлөг дулаалга дахин шинээр хийх, гадна талаар өнгө шавардлага хийж өнгөлөх.	м ³	22,5	
3	Хатуу тор авах, шинээр хатуу тор хийж байрлуулах. Гагнах, хүчитгэх, ребро гагнах.	м ²	104	
4	Хүйтэн пакетын ф219х36мм-н 4ш коллекторын дагуух өрлөг задлах, гарсан дулаалгын хог ачиж зөвшөөрөгдсөн зориулалтын газарт хаях. Өрлөг шинээр өрөх.	м ³	1,5	
5	Таазны уур халаагч дээрх болон халуун, хүйтэн пакет, ширм, бунханы хоорондох шилэн хөвөнг бүрэн гаргах, дахин шинээр хийх.	м ³	26,8	
6	Таазны уур халаагчын 27.5-р тэмдэгтийн харалдаах хоёр талын босоо ханан өрлөг задлах. 300мм-н совлетан ханаар өрөх, гадна талаар өнгө шавардлага хийх	м ³	4,4	
7	Гарсан дулаалгын хог ачиж зөвшөөрөгдсөн зориулалтын газарт хаях зайлуулах.	м ³	4,4	
8	Халуун пакетийн орох, гарах талын 1.2м-н өндөртэй 120мм-н босоо ханан өрлөг задлах. Өрлөг дахин шинээр хийх.	м ³	3	
9	Гарсан дулаалгын хог ачиж зөвшөөрөгдсөн зориулалтын газарт хаях.	м ³	1,6	

10	Ширмэн уур халаагчын орох, гарах талд 0.7м-н өндөртэй 12мм-н босоо ханан өрлөг задлах. Өрлөг дахин шинээр хийх.	м ³	1,6	
11	Гарсан дулаалгын хог ачиж зөвшөөрөгдсөн зориулалтын газарт хаях.	м ³	1,2	
12	Уур хөргөгчийн 1-р үеийн ф273х25мм-н коллекторын галын хотол талын 12мм-н босоо ханан өрлөгө задлах. Өрлөг дахин шинээр хийх	м ³	1,2	
13	Гарсан дулаалгын хог ачиж зөвшөөрөгдсөн зориулалтын газарт хаях.	м ³	13,6	
14	Эргэлтийн хөндийн харалдаах дулаалга задлах, дахин шинээр хийх.	м ³	13,6	
15	Гарсан дулаалгын хог ачиж зөвшөөрөгдсөн зориулалтын газарт хаях	м ³	3	
16	Эргэлтийн хөндийн харалдаах обшивка салгах, дахин шинээр хийх (Хайчлах, матах, өрөмдөх, ажилбарууд бүгд багтаах)	тн	1,6	
17	Эргэлтийн хөндийн харалдаах бетон нягтруулга салгах, дахин шинээр хийх.	тн	1,6	
18	Эргэлтийн хөндийн харалдаах уур халаагчуудын эгнээ хоорондын зай алхам тохируулах, засварлах рыхтовка шинээр хийх, температурын шов шинээр хийж өгөх.	тн	3,5	
19	Эргэлийн хөндийн харалдаах “П,, тулгууруудийг сэргээн засварлах. Хөдөлгөөнтэй ба үл хөдөлгөөнтэй бэхэлгээнүүдийг засварлах, шаардлагатайг нь шинээр солих.	тн	0,8	
20	Бүрээсэн хамгаалалт тогтоох зориулалттай тулгуур бэхэлгээнүүдийг шинээр хийж өгөх./ Эргэлтийн хөндийн харалдаах таазны уур халаагч дээр /	тн	0,3	
21	16ш халуун пакетны хайрцаг доторх бетонуудыг бүрэн салгах, Зайлуулах. Дахин шинээр хийх	м ³	0,8	
22	Хүйтэн пакетийн ф219х36мм-н коллекторуудын завсар хоорондох бетон буулгах. Дахин шинээр хийх	м ³	1,2	
23	16ш ширмийн уур халаагчын бунхан доторх бетонуудыг бүрэн буулгах. Дахин шинээр хийх.	м ³	0,512	
24	Арын экраний 27.5-р тэмдэгт дээрх 12ш өгсөх хоолойн бунханууд доторх бетоныг бүрэн авч зайлуулах. Дахин шинээр хийх	м ³	0,048	
25	Ширмийн уур халаагчын бунхан бүрэн буулгах	тн	0,341	
26	Ширм уур халаагчын бунханг ажлын зургийн дагуу шинээр хийж угсрах. Сам бэхэлгээнүүдийг нэгэн адил шинээр хийж угсрах. Гагнах	тн	0,341	

27	16-н халуун пакетны хайрцагнуудыг бүрэн салгах. ажлын зургыг биетээс гаргаж 4мм-н листээр хайчилж хийх. Ажлын байран дээр хүргэж суурилуулж гагнах. Сам бэхэлгээнүүдийг нэгэн адил хийж өгөх.	тн	0,253	
28	Хүйтэн пакетийн ф219х36мм-н коллекторуудын обшивканыг салгах. ажлын зургийн дагуу шинээр 4мм-н листээр матаж хийх. Ажлын байранд хүргэж угсарч гагнах.	тн	0,201	
29	Арын экраний 27.5-р тэмдэгт дээрх 12ш өгсөх хоолойн бунхануудын хайрцагнуудыг салгах. Ажлын зургийн дагуу 4мм-н листээр хайчилж хийх. Ажлын байран дээр хүргэж угсарч гагнах.	тн	0,043	
30	Таазны уур халаагч, халуун, хүйтэн пакет, ширмний бэхэлгээнүүд / татуурга / чихнүүдийг засварлах, зайлшгүй шаардлагатайг шинээр ажлын зургийн дагуу хийж угсрах.	тн	0,6	
31	Таазны уур халаагчын обшивканыг үзлэг хийж шаардлагатайг огтолж авах, гаргах.	тн	4,5	
32	Таазны уур халаагчын обшивкийг ажлын зургийн дагуу хайчлах, матах, ажлын байран дээр хүргэх, гагнах бэхлэх	тн	4,5	
33	Эргэн тойрны рам бэхэлгээнүүд, шатсан обшивка бүрэн шинээр солих.	тн	1,2	
34	Таазны уур халаагч дээрх бетон нягтруулга салгах, дахин шинээр хийх.	м ²	104	
35	Хоёр талын температурын шовны компенсаторын дээд хэсгээс эргэлтийн хөндийн арын хананы дээд ирмэг хүртэлх 500х100х200мм-н тор болон бетон салгах.	м ³	0,036	
36	10ммын прудокоор 500х100х200мм-н харьцаатай тор хийж байрлуулах.	м ²	7,2	
37	Хоёр талын температурын шовны компенсаторын дээд хэсгээс эргэлтийн хөндийн арын хананы дээд ирмэг хүртэлх 500х100х200мм-н торон дээгүүр бетон шинээр хийж нягтруулах.	м ³	0,36	
38	Таазны уур халаагчын обшивканы бэхэлгээ болон рыброннуудыг шинээр хийж обшивканыг жигд гадрагуугаар нь дарж нягтруулж өгөх.	тн	1	
3.Нүүрний экраний Ф273х25мм коллекторын обшивка б-3мм				
1	Ф273х26мм 4ш коллекторын обшивка цахилгаанаар огтолж салгах. 8,8м ²	тн	0.206	
2	Шаардлагатай материалыг татаж үйлдвэрт хүргэх	тн	0.206	
3	Ажлын зургийн дагуу хайчлах, матах	тн	0.206	
4	Бэлтгэгдсэн маталттай листнүүдийг ажлын байранд хүргэж угсарч гагнах.	тн	0.206	
5	Дулаалга буулгах дахин шинээр хийх.	м ²	9	
4.Агаар халаагчын 2-р үе				

1	Кубнүүдийн хоорондох заадаснуудыг бүрэн шалгаж ханзарсан хэсгийн гагнуурын шовыг бүрэн арилгаж шинээр паска гаргаж гагнах. Дээд доод самбарт гагнагдсан агаар халаагчын шугамнуудад агаарын шахалт хийж илэрсэн гэмтлийг бүрэн арилгуулах засварлах. Шаардлагатай агаарын хоолойнууд дээр насадка шинээр тавих. Эгнээ хоорондын зайг бүрэн гаргах. Гэмтэлтэй тулгууруудыг бүрэн солих.	куб	8	
2	40. Агаарын шахалт хийж илэрсэн гэмтлийг засварлах.	удаа	4	
5. Агаар халаагчын 1-р үе / мөлхөө /				
1	Кубны зам шинээр тавихад хэрэглэгдэх материалыг татаж өргөх механизмын тусламжтайгаар ажлын байранд хүргэх.	Тн	1.5	
2	Куб суглахад зориулалттай зам засах. Замнуудад тулгуур бэхэлгээнүүдийг нэг бүрчлэн хийж хүчитгэх. Буцааж хураах.	Тн	1.5	
3	Куб суглахад зориулалттай леботка болон роликнуудыг байрлуулж өгөх. Тулах болон гүйх зориулалттай тулгууруудыг нэгэн адил шаардлагатай хэсгүүд дээр нэмэж хийж өгөх. Буцааж хураах.	Тн	1	
4	Кубнуудын дээд доод самбар хоорондын гагнуурын оёонуудыг салгах.	куб	8	
5	Гагнуур нь салгагдсан кубнүүдийг нэг нэгээр нь леботка болон өргөх механизмын тусламжтайгаар татаж зассан зам дээр гаргаж ноль тэмдэгтрүү буулгах	Тн	35,3	
6	Хуучин кубны сууж байсан 530мм-н двухтоварын гагнуурын хуучин оёонуудыг цээвэрлэх	м ²	0.38	
7	Куб ажлын зургийн дагуу шинээр хийж угсрах	куб буюу тн	8	Ф-40х1.6мм, 9316ш урт-15838м, 26,6 тн Лист 14 мм-79,04м ² , 9,7тн
8	Шинээр бэлтгэгдсэн кубнүүдийг өргөх механизмын тусламжтайгаар дээш өргөж зассан зам дээр гаргах	куб	8	
9	Зассан зам дээр гарсан шинэ кубнүүдийг леботка болон бусад механик аргын тусламжтайгаар дотогш оруулж байрлуулах.	куб	8	
10	Дотогш орсон кубнуудын төвлөрүүлэлт болон эгнээ хоорондын зайг тохируулах. Гагнах. Харалдаах корбануудыг нэгэн адил гагнаж бэхлэх. Рыбро бэхэлгээг шинээр хийж өгөх .	куб	8	
11	8-н кубны хоорондох хуваариалах самбаруудыг шинээр солих	Тн	0.8	
Агаар халаагчын 1-р үе / дунд секц /				

1	Кубны зам шинээр тавихад хэрэглэгдэх материалыг татаж өргөх механизмын тусламжтайгаар ажлын байранд хүргэх	тн	2	
2	Куб суглахад зориулалттай зам засах. Замнуудад тулгуур бэхэлгээнүүдийг нэг бүрчлэн хийж хүчитгэх. Шаардлагатай газруудад нэмэлт тулгуур байрлуулах. Буцааж хураах.	тн	2	
3	Куб суглахад зориулалттай леботка болон роликнуудыг байрлуулж өгөх. Буцааж хураах.	удаа	2	
4	Агаар халаагчын корбаны дулаалга буулгах, Дахин шинээр дулаалах .	М ²	36	
5	Кубны харалдаах корба огтолж салгах, буцааж шинээр хийх	тн	0,8	
6	Кубны дээд, доод болон хоорондох заадаснуудыг цахилгаан гагнуураар огтолж салгах.	огт	24	
7	Өргөх зөөх механизм болон механик аргын тусламжтайгаар 8н кубийг ээлж дараалан татаж зориулалтын талбайд хүргэх.	Куб	8	
8	530мм-н двухтовар дээрх хуучин гагнуурын оёонуудыг цэвэрлэх	М ²	2.2	
9	Куб ажлын зургийн дагуу шинээр хийх. Ажлын байранд хүргэх	Куб	8	Ф-40х1,6 мм, L-340мм*9316ш урт-31675 м, 48.3тн +10% 53.2тн Лист 14 мм-79,04м ² , 9,7тн Ф-108х5мм L=110м, 1,6тн Лист-20мм 0,3тн 8мм листээр дунд самбар хийх 39,6м ² =2,8тн
10	Шинээр бэлтгэгдсэн кубнүүдийг өргөх механизмын тусламжтайгаар дээш өргөж зассан зам дээр гаргах.	Куб	8	
11	Зассан зам дээр гарсан шинэ кубнүүдийг леботка болон бусад механик аргын тусламжтайгаар дотогш оруулж байрлуулах.	Куб	8	
12	Дотогш орсон кубнуудын төвлөрүүлэлт болон эгнээ хоорондын зайг тохируулах. Гагнах. Харалдаах корбануудыг нэгэн адил гагнаж бэхлэх. Рыбро бэхэлгээг шинээр хийж өгөх	Куб	8	
13	Агаар хуваарилагчуудыг шинээр хийх	тн	2,5	
Агаар халаагчын 1-р үе / дээд секц /				

1	41. Мөлхөө буюу доод секцний кубнүүдийн хоорондох заадаснуудыг бүрэн шалгаж ханзарсан хэсгийн гагнуурын шовыг бүрэн арилгаж шинээр паска гаргаж гагнах. Дээд доод самбарт гагнагдсан агаар халаагчын шугамнуудад агаарын шахалт хийж илэрсэн гэмтлийг бүрэн арилгуулах. Шаардлагатай агаарын хоолойнууд дээр насадка шинээр тавих. Эгнээ хоорондын зайг бүрэн гаргах. Гэмтэлтэй тулгууруудыг бүрэн солих. үлдсэн хэсгийг сэргээн засварлах.	куб	8	
2	42. Агаар халаагчын 1.2-р үеийн галын хотол болон эсрэг талын хэвтээ ба босоо, налуу хэсэг, Баруун зүүн талын корбануудын заадасыг шалгаж ханзарсан, нимгэрсэн хэсгийг шинээр сольж гагнах. Рыхтовка болон рам бэхэлгээнүүдийг шинээр хийж өгөх. Тулгууруудад үзлэг хийж засварлах.	тн	5	
3	43. Агаар хуваарьлагчуудын засварлах. Үзлэг хийх зориулалттай люк, шат тавцанг шинээр хийх	тн	1.5	
4	44. Агаар халаагчын 1,2- р үед агаарын шахалтыг хийж илэрсэн гэмтлийг бүрэн засварлах	удаа	4	
6. Агаар халаагчын корба, компенсаторууд				
1	ДВ "А,Б"-н сорох шахах талруу нийлж байгаа корбануудын нимгэрсэн, цоорсон хэсгийг хэсэгчилэн солих. / 76.8м ² /	тн	1.8	
2	ДВ-н шахах талын / 2ш компенсатор / /5м ² /, рубашик / 3.6м ² /- н хамт салгах	тн	0.135	
3	Ажлын зургийн дагуу хайчлах, матах. Ажлын байран дээр хүргэж угсрах. 2ш	тн	0.135	
4	Дроберийн бункерээс ДС-н шахах талын хана хүртэл 16ш компенсаторуудад үзлэг хийж засварлах, Грунтлэх. Рубашик / 27.2м ² / салгах. компенсаторуудыг солих.	тн	1.3	
5	Дээрх компенсаторуудын рубашикийг ажлын зургийн дагуу 2мм-н листийг хайчилж шинээр солих. (Огтолж гаргах, буцааж байрлуулж гагнах үеийн шат, тавцан болон бусад зайлшгүй гарах нэмэгдэл ажлууд бүрэн орно.)	тн	0.5	

6	Агаар халаагчын 2-р үе доторх 10ш компенсаторт үзлэг хийх засварлах. Грунтлэх. Рубашик / 12м ² / салгах.	тн	1.8	
7	Дээрх компенсаторуудын рубашикийг ажлын зургийн дагуу 2мм-н листийг хайчилж шинээр солих. (Огтолж гаргах, буцааж байрлуулж гагнах үеийн шат, тавцан болон бусад зайлшгүй гарах нэмэгдэл ажлууд бүрэн орно.)	тн	0.8	
8	Рециркуляцийн шугамыг ДВ-н сорох хоолойд 9,6-р тэмдэгтийн харалдаа холбох.	м	4	
7.Шибер, люк, шагайвар				
1	Рециркуляцийн шибер Ф600 2ш компенсатор, нимгэрсэн шугам тус бүрийг шинээр солих. 6-5мм. Тэмдэглэгээнүүдийг хийх.	тн	2	
2	Хоёрдогч агаарын шибер ф1100 6ш тус бүр задлаж засварлах. Тэмдэглэгээнүүдийг хийх .	ком	6	
3	Хүйтэн агаарын шибер ф1120мм засварлах	ш	2	
4	Халуун агаарын шибер ф1120мм засварлах	ш	2	
5	Халуун хийн шибер ф1120мм засварлах	ш	2	
6	Зууханд суурилагдсан люк шагайваруудыг бүрэн задалж засварлах. Шаардлагатай люкнүүдийг биетээс нь ажлын зураг гаргаж шинээр люк 4ш хийж угсрах. ф500мм	люк	10	
7	Уур халаагчын А,Б тал люк 2ш, Экраны нүүрний 9,6-р тэмдэгтийн 2ш, ширмэн люк ф600х510 солих	люк	4	
8.Горёлка №1-6 засвар				
1	Мазутын фросункийг бүрэн суглаж авч засварлах. Соплонуудыг шинээр солих	ком	6	
2	Горёлкыг задлаж суглаж гаргах. Элэгдсэн хоолой болон фланцуудыг бүрэн огтолж шинээр солих. Далбаануудыг бүрэн солих	ком	6	
3	Горелканы доторхи хоолойг солих ф219х10мм 100% солих, гадна хоолой ф600х10мм хоолойг 100% солих.	ком	6	
4	Горелканы тяга, нугасан холбооснууд, бэхэлгээ татуургануудад үзлэг хийж засварлах. Элэгдсэн хэв гажилтанд орсон шатсан хэсгийг бүрэн шинээр солих.	ком	6	
5	Язенковийн шиберийг бүрэн задалж салгах засварлах. Чөлөөтэй хөдөлгөдөг болгох. Бүрэн ажиллагаагүй болсон шиберийг солих. / тяга. чөмөг. нугасан холбооснууд. зам / засварлах буюу шинээр солих. Солигдох шаардлагатай дээрхи эд ангиудыг ажлын зургийн дагуу шинээр хийж угсрах	ком	6	

6	Горелканы гаднах корбанд үзлэг хийж нимгэрсэн цоорсон хэсгийг бүрэн авч солих. Штыр бэхэлгээнүүдийг шинээр хийж өгөх	КОМ	6	
7	Горелканы эд ангийг бүрэн засварлаж дууссаны дараа угсралтыг технологийн дагуу угсарч өнцөг болон төвлөрүүлэлтийг хийх. Нягтруулгуудыг шинээр хийж өгөх	КОМ	6	
8	6ш горелка тус бүрд орж байгаа корбануудын нимгэрсэн хэсэг, татуурга бэхэлгээнүүд, компенсаторыг солих. / Салгах. буулгах. хийц хийх. угсрах үеийн бүх ажлууд багтана /	КОМ	6	
9	Горелканы амбарзуурын бетон шинээр хийх	М ³	3	
10	Горелка №1,2,3,4,5,6-н дулаалга буулгах, дахин шинээр хийх	М ³	6	
11	Тоосны шугам№1-6 нимгэрч цоорсон хэсгүүдийг шинээр солих. Ф426х10мм	п/м	24	
9. Хаалт арматур				
1	ГПЗ-1 буюу Ду225 Ру100 цахилгаан хаалтыг засварлах. /редукторын хамт/	Ш	1	
2	ГПЗ-1-н дараах агаар гаргагч Ду65 Ру100 хаалт засварлах	Ш	2	
3	РОУ-н гар хаалт Ду100 Ру100 засварлах	Ш	1	
4	Продувкийн К-2 Ду65 Ру230-н цахилгаан хаалт засах. /редукторын хамт/	Ш	1	
5	Продувкийн К-130 Ду65 Ру230-н цахилгаан хаалт солих	Ш	1	
6	Консервацын Ду65 Ру230-н хаалтнуудыг бүрэн задалж засварлах.	Ш	2	
7	Барабаны арын агаар гаргагчын Ду10 Ру100 12ш хаалт сольж, 12ш хаалт бүрэн задалж засварлах.	Ш	24	
8	Барабаны арын агаар гаргагчын бронк сэргээн засварлах	ТН	0.2	
9	Барабан халаагч: Ду65 Ру100-н гар хаалтнуудыг бүрэн задалж засварлах.	Ш	5	
10	Тогооны шилний ууран талын Ду20 Ру100 хаалт 2ш солих, 2ш засах	Ш	4	
11	Тогооны шилний усан талын Ду20 Ру230 хаалт 2ш солих, 2ш засах	Ш	4	
12	Тогооны шилний дренаж Ду20 Ру230 хаалтуудыг засварлах .	Ш	2	
13	Тогооны шилний уур, усан талын Ф-32мм шугамыг бүрэн солих	п/м	12	
14	Тогооны шилний клонко сэргээн засварлаж, слюда шинээр солих. “Б,,	КОМ	1	
15	Цахилгаан тогооны шил шинээр солих	КОМ	1	
16	Сорьцын цэгийн хөргөлтийн усны Ду 50 Ру16 фланцтай хаалт солих	Ш	4	
17	Сосудын усан талын Ду20 Ру230 хаалтыг бүрэн задалж засварлах	Ш	10	
18	Үргэлжийн үлээлгийн гар Ду20 Ру100 хаалтыг солих	Ш	2	

19	Үргэлжийн үлээлгийн Ду20/Ру100 регуляторыг засварлах	ш	1	
20	Уур цуглуулах камер дээрх Ду10 Ру100 хаалтууд солих	ш	5	
21	Барабан дээрх Ду10 Ру100 температурын анхдагч хаалтнуудыг солих. Нийт 5ш .	ш	5	
22	Фосфатын Ду20 Ру230 хаалтыг солих. Хамгаалах клапан засварлах.	ш	2	
23	Экономайзерийн рециркуляцын К-14, К-132 Ду65 Ру230-н цахилгаан хаалтуудыг засах	ш	2	
24	Үндсэн клапан, Контролны клапанг засварлах. Ду175 Ру200 Сталь15Х1МФЛ	ком	2	
25	Импульсний хамгаалах клапанг засварлах ИПК	ком	2	
26	Экономайзерийн 2-р үеийн дренаж хаалтууд задалж засварлах. Ду20	ш	4	
27	Аваарын юлүүрийн цахилгаан Ду65 Ру100 хаалтыг засах. редукторын хамт	ш	2	
28	Дээд циклоны сорьцын Ду10 Ру100 5ш хаалт сольж 7ш хаалт засварлах.	ш	12	
29	Впрыскийн узель дээрх Ду20 Ру100-н регулятор засах	ком	1	
30	Впрыскийн узель дээрх Ду65 Ру100-н регулятор засах	ком	1	
31	Впрыскийн узель дээрх Ду20 Ру100-н регулятор засах	ш	1	
32	Впрыскийн узель дээрх Ду65 Ру100-н регулятор засах	ш	1	
33	Впрыскийн дээд узелийн дренажны Ду20 Ру230 хаалт солих	ш	5	
34	Уур хөргөгчийн 1,2-р үеийн дренаж Ду20 Ру180 хаалтыг засварлах. Нийт-3ш	ш	3	
35	Завсарын коллекторын дренаж Ду20 Ру230 солих	ш	3	
36	Уур халаагчийн коллекторуудын дренажыг салгаж тус тусад нь монтажлах. Ф38х7мм	п/м	22	
37	Экономайзерийн 1-р үеийн дренаж Ду65 Ру230-н 2ш хаалтыг засварлах.	ш	2	
38	Экономайзерийн 1-р үеийн агаар гаргагч Ду20 Ру230-н хаалтыг задалж засварлах	ш	1	
39	Впрыскийн доод узель дээрхи конденсатын ерөнхий хаалт Ду100 Ру100-г цахилгаан засварлах	ш	1	
40	9.6-н сорьцын цэгийн Ду10 Ру100-н 5ш вентиль сольж 7ш вентилийг задалж засварлах. Нийт: 12ш .	ш	12	
41	Земеевикүүдийг шинээр ороож. Угсрах. Ф12х4мм нерж труба. 46п/м	п/м	46	
42	Сорьцийн цэгийн хөргөлтийн усны ирэх, буцах Ф-83х4мм шугам 100% солих	п/м	20	

43	Горёлка №1-6-ын мазут болон уурын хаалт солих. Ду20 Ру230. Нийт 24ш. 12ш солих	ш	24	
44	Гүний үлээлгийн узель дээрх Ду65Ру100 гар хаалт солих	ш	2	
45	Доод цэгийн коллектор Ф133х8мм шугам бүрэн солих	м	8	
46	Доод цэгийн хаалт Ду20 Ру230-н хаалт засварлах.18ш солих	ш	36	
47	Доод цэгт ГЗУ Ду65 Ру230 хаалтыг солих .	ш	2	
48	Тэжээлийн усны узелийн Ду100 Ру230-н задвишик солих. К-7	ш	1	
49	Тэжээлийн усны узелийн дренажын коллекторын Ф60х6мм шугам 100% солих. Булан Ф60х6мм 3ш	м	8	
50	Ду100 Ру230 гар хаалт бүрэн задалж засварлах	ш	1	
51	Ду175 Ру230 задвишик засварлах шаардлагатай бол солих /К-6 /	ш	1	
52	Тэжээлийн усны кр-9 регулятор засах Ду175 Ру230	ком	1	
53	Тэжээлийн усны кр-10 регулятор засах Ду100 Ру230	ком	1	
54	Ду175 Ру230 гар хаалт бүрэн задалж засварлах.	ш	1	
55	Ду175 Ру230 буцаахгүй клапанг бүрэн задалж засварлах	ш	1	
56	Ду175 Ру230 цахилгаан хаалт засварлах /К-5/	ш	1	
57	Дренажны шугам дээрх Ду20 Ру230-н хаалт задалж засварлах	ш	14	
58	Тэжээлийн усны узель Ду65 Ру230 гар хаалтыг засварлах.	ш	1	
59	Тэжээлийн усны узель сорьцын анхдагч зарцуулалтын хэмжүүрийн хаалт Ду10 Ру230 хаалт засварлах	ш	2	
60	Уурын зарцуулалтын шайбны Ду10 Ру100 вентиль засварлах, шугам солих	ш	6	
61	Турбавентур дээрх Ду80 Ру25 хаалт солих	ш	4	
62	Турбавентурын ерөнхий хаалт Ду80 Ру25 хаалт солих	ш	1	
63	Давс тэнцүүлэгч Ду65 Ру230 хаалт задлаж засварлах	ш	2	
64	Скрубберийн тавцангийн харалдаах аваар юүлүүрийн Ду65 Ру100 гар хаалт задлаж засварлах	ш	1	
65	Шнек ванны хөргөлтийн усны ДУ80/25 фланцтай хаалт солих	ш	2	
66	Скрубберийн тавцангийн харалдаах уур халаагчын дренажын Ду65 Ру100-н гар хаалт задлаж засварлах	ш	1	
67	Зуухны давслагын шугам солих. Ф60х4,5мм "А,Б" талд	п/м	420	
68	Тэжээлийн усны узелээс доод цэг хооронд ИГЛА-н шугам солих	п/м	24	
69	Аваарын сливийн шугам солих Ф76х6мм	п/м	60	

70	Тэжээлийн усны рециркуляци үзлэг хийж солих Ф60х4,5мм	п/м	65	
71	Уур хөргөгчийн собствений кондинсатын коллектор, шугамд 100% металлын шинжилгээ хийж солих. 60х4,5мм	п/м	24	
72	Уур хөргөгчийн собствений кондинсатын дулаан солилцуурыг задлаж засах	ком	2	
73	Барабан экномайзерийн рециркуляцийн шугамд металл шинжилгээ хийж шаардлагтай хэсгийг солих Ф76х6	п/м	30	
74	Барабанаас гарсан импульсын нерж шугамыг бүрэн солих. Ф16мм	п/м	276	
75	Мазутын кольцог бүрэн солих. Ф60х4мм	п/м	100	
76	Тавцан болгон дээр тэмдэгтийг харуулсан тэмдэглэгээнүүдийг. Бүх хаалт арматур болон доод цэгүүдийн хаалт. сорьцын цэгийн хаалтнууд дээр таних тэмдэглэгээнүүдийг өнгө үзэмжтэй хийх .	тн	0.4	
10.Гүний үлээлгийн аппарат				
1	Уур халаагчын аппарат засварлах. Үүрийг ф133х10мм нерж трубагаар хийх. Эргэн тойрон үүр сэргээн засварлах.	ком	2	
2	Зуух тойрсон тавцангууд цөмөрсөн, илжирсэн хэсгийг хээтэй листээр солих, засварлах	тн	1	
11.Будагны ажил				
1	Зуухны үндсэн балкнууд, шат тавцан хашлага, хүрээг засварлах. Шаардлагатайг нь шинээр солих	м ²	120	
2	Зуухны үндсэн балкнууд, шат тавцан хашлага, хүрээ, эргэлтийн хөндийн гадна корбануудыг будах.	м ²	160	
3	Бүх хаалт арматуруудыг будах	м ²	17.2	
12.Өрлөг, дулаалга				
1	Хажуу экраний (А,Б) дээд коллектороос барабанд холбогдож байгаа өгсөх /Ф133х12мм / хоолойн дулаалга сэргээн засварлах 5мм-н зузаантай өнгөлөх S=70.5м ² Урт=172м	м ³	0.4	
2	Нүүрний экраний дээд 4н коллектороос барабанд холбогдож байгаа өгсөх Ф133х12 мм хоолойн дулаалга сэргээн засварлах. 5мм-н зузаантай өнгөлөх. S=40м ² Урт=97.4м	м ³	0.2	
3	Арын экраний 4-н дээд коллектороос дээш барабанд холбогдож байгаа өгсөх /Ф133х12мм / хоолойн дулаалга сэргээн засварлах. 5 мм-н зузаантай өнгөлөх. S = 40м ² . Урт=97п/м	м ³	0.2	
4	Уур халаагчын коридор 8.2м ² болон мөргөцөгийн налуулгийн 30м ² хагарсан	м ²	38.2	

	нурсан бетон, өрлөгийг шинээр хийх үлдсэнг сэргээн засварлах, бетондох. Гадна талын завсар байгаа обшивка шинээр матаж солих.			
5	Эргэлтийн хөндийн арын хэсгийн хананы өрлөгийг шинээр хийх хагарсан хөндийрсөн бетоныг сэргээн засварлах, бетондох.	м ²	35	
6	Эргэлтийн хөндийн хоёр талын хананы өрлөгийг шинээр хийх хагарсан бетонуудыг сэргээн засварлаж бетондох. Хананы өргөн- 4.456м. Өндөр-4.5м	м ²	24	
7	Уур халаагчын 2 талын хананы өрлөгийг шинээр хийх хагарсан цуурсан бетоныг засварлаж бетондох. Хоёр талын люкны орчмын хэсэг нэгэн адил бетондоно.	м ²	14.4	
8	Уур халаагчын 2 талын халуун пакетын харалдаах хананы өрлөгийг шинээр хийх хананы хагарсан цуурсан бетоныг засварлаж дахин шинээр бетондох.	м ²	28	
9	Температурын шовны муудсан хагарсан бетоныг бүрэн буулгаж дахин шинээр хийх. 7000x450x300x2	м ³	2	
10	Агаар халаагчын 2-р үеийн доторх саран компенсаторын орчим эргэн тойрон 120мм-р өрлөг өрж гадна талаар нь бетондох. 10000x120x240x2. 5500x120x240x2.	м ³	1	
11	Экономайзерийн 2-р үеийн дор: Ар, нүүр болон хоёр талын хажуу хананы хагарсан бетонуудыг сэргээн засварлах 2 люкны орчим нэгэн адил орно.10000x1400x2. 5500x1400x2.	м ²	43.4	
12	Доод цэгийн муудсан дулаалгуудыг сэргээн засварлах өнгөлөх. 120п/м. Ф32x5мм.	м ²	12	
13	4,7-р отметик дээрхи шугамнуудын ф60x6мм дулаалгыг бүрэн шинээр хийх. Хуучин, муудсан дулаалгыг бүрэн салгах.12 п/м	м ²	2.2	
14	Давс тэнцүүлэгч Ф60x6мм-н шугамны дулаалга сэргээн засварлах. 350п/м	м ²	17.5	
15	Барабаны арын уур хөргөгчийн хоёр коллекторын дулаалгыг сэргээн засварлах. урт-9.5п/м. Дулаалгын зузаан 200мм. Ф530мм.15.8м ²	м ³	3.2	
16	2-ч агаарын шибerrүү Ф1100 очиж байгаа Ф1120x3мм шугамны / 4.250x6=25.5м / болон 2-ч агаарын ф1120x3мм шибerrээс горелка руу очиж байгаа Ф1120x3мм шугамны дулаалгыг / 2,048x6=12.3м / сэргээн засварлаж 5мм-н зузаантайгаар өнгөлөх. Нийт шугамны урт: 37.7п/м S=132.5м ²	м ³	0.7	
17	Экономайзерийн II-р үеийн доорх агаарын хөргөлтийн балкны гадна	м ³	1.3	

	талын бетон бүрэн буулгах дахин шинээр хийх.S=13.2м2			
18	Зуухны конвектив хэсгийн бүх халаагчуудад горимын туршилтын хэмжилтийн цэг гаргах, шаардлагатай цэгүүдийг нэмж хийж өгөх. Шаардлагатай шат тавцангуудыг барьж өгөх.	ш	20	
19	Потолокны эргэн тойрон битүүмжлэл нягтруулга хийх	м ²	12	
20	Таазны уур халаагч дээгүүр азбестан нягтруулга шинээр хийж өгөх	м ²	149	
21	Эргэлтийн хөндийн харалдаах таазны уур халаагчын дээр 49.5м ² талбайд 300мм-н зузаантайгаар шилэн хөвөн тавьж бүрээслэх буюу бетондох	м ³	8.9	
22	Таазны уур халаагч дээр температурын шовноос хүйтэн пакетын захийн коллектор хүртэл хоёр талдаа 200x100x3800x2 харьцаатай арматур зангидаж бетон цутгах	м ³	0.4	
23	Эргэлтийн хөндийн арын хэсэг дээр: 200x100x9500 харьцаатай Арматур зангидаж бетон цутгах	м ³	0.4	
24	Агаар халаагчын 2-р үеийн мөргөцөгийн хагарсан хөндийрсөн хэсгийг салгах. Дахин өрлөг өрж бетондох.	м ³	2	
25	Тэжээлийн усны дулаалга буулгаж дахин шинээр хийх. 10К70-с экономайзерийн 1-р үе хүртэл	м ²	35	

13.Утааны хийн трактын дагуух ажил

1	Дробны бункерын дараах хоёр хавтгайн дээд, доод ёроол, баруун, зүүн хананд үзлэг хийж засварлах, шаардлагатай хэсгийг шинээр хэсэгчлэн солих /123м2/	тн	0.8	
2	Дробны бункерийн люкийг сүүлийн хэсэг талруу харуулаж хийх	ш	2	
3	Скруббер №1,2,3,4-н хөмсөгнөөс дээших босоо цилиндр хоолойн доторх тогтсон үнсэн давхаргыг цэвэрлэж буулгах, ханад нь үзлэг хийж засварлах. Бетон хийх.	м ³	8	
4	Утаа сорогчийн шахах талын компенсатор бүрэн солих.	тн	0.8	

14.Скруббер№1,2,3,4. Трубовентур№1,2,3,4

1	Хуучин кольцонуудыг салгах / ф108мм-н трубагаар матсан ф3216мм-н диаметртэй 4ш кольцо/	ш	4	
2	Резин жийрэгнүүдийг шинээр солих.	ш	8	
3	Боолт гайкнуудын резьбануудыг сэргээх.	ш	32	
4	Салгасан кольцог сэтгэж цэвэрлэх.	ком	4	
5	Бэлэн болсон кольцог өргөх механизмын тусламжтайгаар ажлын байран дээр хүргэж угсрах. / ф3216мм-н диаметртэй 4ш кольцо/	тн	0.4	

6	Кольцо тус бүрийн тулгуур бэхэлгээнүүдийг шинэчилж хийх.	тн	0.1	
7	Скруббер тус бүр дээрх нерж ф12мм-н соплоуудыг салгах.	ш	96	
8	Ф12мм нерж трубаг 450мм-н урттай тайрч бэлдэх.	ш	96	
9	Бэлтгэгдсэн ф12мм-н 450мм-н урттай нерж хоолойг гадна талаар нь бөгжилж ажлын байранд хүргэж угсрах. Өнцгүүдийн градус тохируулах, бэхлэж гагнах	стык	96	
10	Ф12мм диаметртэй 400мм-н урттай 96ш соплоны шланг бэлдэх.	ш	96	
11	Бэлтгэгдсэн шлангуудыг угсрах, бэхлэх. 2 талдаа угсрагдах	ш	192	
12	Хөмсөгний бетонийг бүрэн буулгаж гадагш гаргах. Дахин шинээр бетон хийх. / 2м ³ /	м ³	2	
13	Хуучин хөмсөгийг цахилгаан ба хийн огтлогчийн тусламжтайгаар бүрэн салгаж гаргах.	тн	0.635	
14	Ажлын байран дээрээс ажлын зураг гаргаж шинээр хөмсөг огтолж бэлдэх.	тн	0.635	
15	Трубовентур №1,2,3,4-н багалзуур хэсэг дээр нерж оруулга шинээр хийх, хөндийрсөн плитануудыг салгах, дахин шинээр бетон хийх, плита хийх.	ш	88	
16	Т/В №1.2.3.4-н доторх металл гадаргуугийн өнгөлгөө хийх. Ф2420мм, тойрогийн урт-7.6м, өндөр-0.235м	м ²	7.1	
17	Өнгөлгөө хийгдсэн хэсгүүд дээр бэлдсэн плитануудыг шинээр технологийн дагуу наах. 1ш плитаны харьцаа: 235x5x110мм	м ²	7.1	
18	Наасан плитанууд дээрээ арзамитаар өнгөлөх.	м ²	7.1	
19	Угсардаг шат тавцан барих, буулгах.	удаа	4	
20	Скруббер №1,2,3,4-н гаднах гадрагуу болон шат тавцан хашлагуудыг будах.	м ²	340	
21	Трубовентур №1,2,3,4-н гаднах гадаргуу болон шат, тавцан хашлагуудыг будах.	м ²	120	
22	Шат, тавцан, хашлага, хүрээг засварлах. Шаардлагатай хэсгүүд дээр шат тавцан, хашлага шинээр хийж өгөх	тн	0.6	
23	Скруббер №1,2,3,4, трубовентур №1.2.3.4-н люкнүүдийн ажлын зургийг биетээс гаргаж шинээр хийж угсрах, бетон хийх, хуучин люкнүүдийг салгах.	люк	12	
24	Трубовентур №1,2,3,4-н коробны дотор үзлэг хийж засварлах, нимгэрч цоорсон хэсгийн хэсэгчлэн солих, грунтлэх. Дулаалга буулгах дахин дулаалга шинээр хийх.	м ²	38	
25	Скруббер №1,2,3,4-н их биений нимгэрсэн хэсгийг оруулга хийж солих. Дулаалга буулгах дахин дулаалга шинээр хийх.	тн	1,4	

15. Гадаад циклон

1	Гадаад циклон дулаалга авч заглушка авч угааж цэвэрлэх. Заглушка паскдаж гагнах. Дулаалга дахиж шинээр хийх	ш	4	
2	Шат тавцан барих, буцааж хураах	удаа	2	
3	Экраны өгсөх, буух хоолойн булангуудад дулаалга авч үзлэг хийж шаардлагатай булангууд солих дахин дулаалах	ш	20	

МЕТАЛ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ

Д. Д	ХИЙГДЭХ АЖЛЫН АГУУЛГА	ХЭМ-ЖИХ НЭГЖ	ТОО, ХЭМ-ЖЭЭ	ТАЙЛБАР
